



**УЛАМЖЛАЛТ МАЛ АЖ АХУЙД ТУЛГАМДАЖ БҮЙ УУР АМЬСГАЛЫН
ӨӨРЧЛӨЛТӨӨС ШАЛТГААЛСАН СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ
БУУРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага:

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 5 дахь хэсэгт “Мал сүрэг бол үндэсний баялаг мөн бөгөөд төрийн хамгаалалтад байна.” гэж хуульчилан, Монгол Улсын Их Хурлын 2010 оны 07 дугаар сарын 15-ны өдрийн 48 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 1.1.6-д “Үндэсний түүх, хэл, соёл, өв уламжлал, зан заншлаа хадгалж, хамгаалж хөгжүүлэх нь Монгол үндэстний оршин тогтнохын үндэс, амин чухал дархлаа мөн.” гэж заасан.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-ын “Хөдөлмөр эрхлэлт ба гарааны бизнес” зорилтын 3.3-т “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, бизнес эрхлэх арга, ур чадварыг хөгжүүлж, жижиг, дунд бизнес эрхлэлтийн өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ.” гэж, “Тогтвортой хөдөө, аж ахуй” зорилтын 8.3-т “Хөдөө аж ахуйг байгальд ээлтэй, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон, эрсдэл даах чадвартай, нийгмийн хөгжлийн чиг хандлага, хэрэгцээ, шаардлагад нийцсэн, хариуцлагатай, бүтээмж өндөр, тогтвортой үйлдвэрлэлтэй эдийн засгийн тэргүүлэх салбар болгон хөгжүүлнэ.” гэж тус тус заасан.

Дээрх зорилтын хүрэх үр дүнг “малчин, тариаланчдын 75 хүртэл хувийг өрхийн аж ахуй эрхлэхэд нь хүрэлцэхүйц чадалтай цахилгааны эх үүсвэр, техник, технологиор хангах, хөнгөлөлттэй нөхцөлөөр зээл болон бусад төрлийн санхүүгийн дэмжлэг үзүүлэх, малчин өрх, тариаланчдын бэлтгэсэн бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх оновчтой тогтолцоог бий болгосон байна. Малчид, тариаланчид бизнесийн тогтвортой

орлогын эх үүсвэртэй болсон байна.” гэж, “Нүүдлийн уламжлалт өв соёлыг хадгалсан, экологид ээлтэй, органик мал аж ахуйг тогтвортой эрхлэх, хөдөө аж ахуйн эрчимжсэн үйлдвэрлэлийг төрөлжүүлж, кластер, логистик, санхүүгийн түрээсийн үйлчилгээг хөгжүүлж, төлөвшүүлнэ. Хөдөө аж ахуйн салбарын хүний нөөцийг бэлтгэх, чадавхжуулах, хөдөлмөрийн үнэлэмжийг нэмэгдүүлэх, тэдгээрийн тогтвор суурьшилтай ажиллаж, ая тухтай амьдрах нөхцөл, нийгмийн баталгааг сайжруулна. Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний гадаад зах зээлийг тэлж, зарим нэр төрлийн түүхий эд, бүтээгдэхүүний импортыг халж, экспортыг нэмэгдүүлнэ.” гэж тус тус тодорхойлсон.

Дэлхийн дулаарлаас үүдэн сүүлийн 80 жилд агаарын жилийн дундаж температур 2.36 градусаар дулаарч, хур тунадасын хэмжээ 7 хувиар буурсан нь манай орны усны эх үүсвэрт нөлөөлж, хуурайшилт нэмэгдэн, бэлчээр доройтож, мал аж ахуйн үйлдвэрлэлд нөлөөлөн, улмаар экосистемийн үйлчлэлд суурилсан мал аж ахуйн салбарын чадавхийг доройтуулж байгаагаар илэрч байна.

Сүүлийн 70 гаруй жилд манай оронд 13 удаагийн зудын улмаас нийт 45 сая толгой мал хорогдсон бөгөөд 2010 онд нийт малын 22% нь хорогдож, 8.6 мянган малчин өрх малгүй болж, 32.8 мянган малчин өрх нийт малын 50 хувийг алдсан бол 2016 онд зудын хохирлын хэмжээ 18 тэрбум төгрөгт хүрсэн байна.

Мал аж ахуйн салбарын өвөлжилт, хаваржилт хүндэрч, холбогдох мэргэжлийн байгууллагын зудын нөхцөл байдалд хийсэн үнэлгээ, дүгнэлтээр (2024 оны 03 дугаар сарын эхний 10 хоногийн байдлаар) улсын хэмжээнд **10** аймгийн **37** суманд **“мөсөн (төмөр) зуд”, 16** аймгийн **130** суманд **“цагаан зуд”, 14** аймгийн **49** сум, **нийслэлийн 4 дүүрэгт “цагаанаар зудархуу”,** нийт 21 аймгийн 216 сум, нийслэлийн 4 дүүрэгт хаваржилт хүндэрсэн нөхцөл байдалтай байна.

Мал аж ахуйн салбарын судалгаа, мэдээллээр оны эхэнд тоологдсон нийт малын **6 хувиас дээш хорогдсон** тохиолдолд **гамшгийн түвшинд хүрсэн** гэж үздэг байна. Гэтэл энэ оны өвөлжилт, хаваржилтын хүндрэлийг улмаас 04 дүгээр сарын 08-ны өдрийн байдлаар улсын хэмжээнд **нийт 6.3 сая мал** хорогдсон нь оны эхний нийт малын **9.6 хувийг эзэлж** байгаа нь **мал аж ахуйн салбарт гамшиг тохиолдож**, эдийн засаг, нийгмийн дотоод нөөц, боломжоос давсан хохирол учирсан байгааг харуулж байна. Түүнчлэн, малчин өрхийн түвшинд гарсан малын хорогдлын мэдээгээр оны эхний малынхаа 70 хувийг хорогдуулсан 1521 өрх, 80 хувийг хорогдуулсан 732 өрх, 90 хувийг хорогдуулсан 326 өрх, огт малгүй болсон 380 өрх байна.

Ган, зудын давтамж нь малчин өрхийн амьжиргаа, тогтвортой байдал, орлогын эх үүсвэрт сөргөөр нөлөөлж, ядуурлыг нэмэгдүүлэх, хөдөөгөөс хот руу чиглэсэн шилжилт хөдөлгөөнийг эрчимжүүлэх нөхцөлийг үүсгэхээр байна.

Уламжлалт бэлчээрийн мал аж ахуйн салбар нь улсын нийт газар нутгийн 72.1 хувийг ашиглаж, ДНБ-ий 10.5 хувийг үйлдвэрлэж, нийт ажиллах хүчний 21.6 хувь нь тус салбарт ажиллаж улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд чухал үүрэг гүйцэтгэж байгаа боловч уур амьсгалын өөрчлөлтөд өртөмтгий, бэлчээрийн даац хэтэрсэн, сүргийн зохистой харьцаа алдагдсан байдал нь цаашид мал аж ахуйн салбарын бодлогыг тогтвортой, үр ашигтай хөгжүүлэхийг зүй ёсоор шаардаж байна.

Малчдын үйл ажиллагаа, амьжиргаанд шууд болон шууд бусаар нөлөөлж буй хүчин зүйлсийн нөлөөллийг бууруулах, мал аж ахуйн салбарыг тогтвортой, үр ашигтай хөгжүүлэхийн тулд малчдыг төрийн бодлогоор дэмжих, тэдний идэвх санаачилга, нийгмийн оролцоог нэмэгдүүлэх, чадавхжуулах, хөгжлийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх шаардлагатай гэж үзэж байна.

Монгол Улсын Үндсэн хууль, "Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал"-д тодорхойлсноор хөдөө аж ахуйн, тэр дундаа мал аж ахуйн салбар нь манай улсын эдийн засгийн бие даасан байдлыг хангах гол салбарын нэг учраас Монгол Улсын Засгийн газраас мал аж ахуйн салбарыг уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллөөс хамгаалах, учирч болзошгүй эрсдэлийг даван туулах шуурхай арга хэмжээ авч хэрэгжүүлэн малчдын амьжиргааг дээшлүүлэх, тэдний хамтын санаачилга, малчдын хоршоог дэмжин улмаар мал аж ахуйн үйлдвэрлэл, мал аж ахуйн салбарыг тогтвортой хөгжүүлэх зорилгоор Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж буй уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төслийг боловсруулна.

Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ:

Хуулийн зорилт нь уламжлалт мал аж ахуйн салбарыг уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллөөс хамгаалах, малчдад учирсан эрсдэлийг бууруулах арга хэмжээг онцгой журмаар шийдвэрлэхэд чиглэх бөгөөд хуулийн төсөлд дараах асуудлыг тусгана:

1.уламжлалт мал аж ахуйн салбарыг уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллөөс хамгаалах, малчдад учирсан эрсдэлийг бууруулах арга хэмжээнд баримтлах зарчим, Улсын Их Хурал, Засгийн газрын бүрэн эрх, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, орон нутгийн төрийн захиргааны байгууллаас авч хэрэгжүүлэх үйл ажиллагааг,

2.уламжлалт мал аж ахуйг уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллөөс хамгаалах, эрсдэлийг бууруулах, давах туулахад малчид, малчдын нэгдэн, үүсгэн байгуулсан хоршооны эрх, үүргийг.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал:

Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж буй уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль батлагдсанаар гамшгийн улмаас малгүй, амьжиргааны эх үүсвэргүй болсон малчдад дэмжлэг үзүүлж, малчин өрхүүд эдийн засаг, нийгмийн эрэлт хэрэгцээгээ хамтран хангах боломж бүрдэж, гамшгийн эрсдэлийг бууруулна.

Дөрөв.Хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд

шинээр боловсруулах, шинэчлэн найруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаарх санал:

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон холбогдох бусад хуульд нийцүүлэн боловсруулна.

Хуулийн төсөлтэй холбогдуулан Зээлийн батлан даалтын тухай, Хоршооны тухай, Газрын тухай, “Үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 2011 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 30 дугаар тогтоол зэрэг хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, тогтоолын төслийг боловсруулна.

---000---